# “ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ” ОНӨААТҮГ-ЫН 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ (Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж) | Төсөв эх үүсвэр (сая.төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар) | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ.НЗДҮАХ-ИЙН 6.3. “УЛААНБААТАР ХОТЫН ХӨГЖЛИЙГ ХАНГАСАН, СТАНДАРТАД НИЙЦСЭН ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЖ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, ИРГЭДИЙН АЯ ТУХТАЙ АМЬДРАХ НӨХЦЛИЙГ БҮРДҮҮЛНЭ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:** | | | | | | | |
| 6.3.14.Нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи бүхий, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тээвэрлэх тоноглол бүхий тээврийн хэрэгслийг үе шаттайгаар нэвтрүүлнэ. | | | | | | | |
| 1 | Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд цахилгаан автобусаар нийслэлийн зориулсан орон нутгийн зээллэгийн урген төлөлтийг батлагдсан хуваарийн дагуу гүйцэтгэж, тайланг сар, улирал тутамд тайлагнаж ажиллана. | 14,308.9 Нийслэлийн төсөв | Цахилгаан автобусны тоо | 36 | 2 давхар цахилгаан автобус-10 | Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд нийтийн тээврийн парк шинэчлэлтийг 2022 оны эхний хагас жилийн байдлаар 2 давхар цахилгаан автобус-10 шугамын үйлчилгээнд нэвтрүүлсэн. | 100% |
| 2 | Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын автобус паркийн барилгын II ээлж барих ажлыг үргэлжлүүлнэ. | 10,000.0 (Нийслэлийн төсөв) | Барилгын ажлын хэрэгжилтийн хувь | 50% | 100% | "Нийтийн тээврийн автобус парк" барихаар 4,3 га газарт нийт 11 ажлын зураг, төсвийг 2018 онд Нийслэлийн зураг төслийн хүрээлэн хийж гүйцэтгэсэн. | 40% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2018-2022 онд ажлын зураг, төсвийн дагуу нийт 12 компани, ахуйн нэгж байгууллага паркийн барилгын ажлыг гүйцэтгэж байна.<br>Тайлант онд: "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын - автобус паркийн<br>-Ногоон байгууламж, зам талбайн ажил хийгдээгүй-0%<br>-Автобус паркийн харуулын байр барих ажил хийгдэж байна-85%<br>-ШТС, уурын зуух, худаг барих ерөнхий ажлууд хийгдэж байгаа-85%<br>-Дэд бүтэц хийгдэж байгаа-45%<br>- Хашааны суурь бүрэн цутгагдсан-45%<br>-Цахилгаан хангамжийн ажлууд хийгдэж байна-10%-гэсэн гүйцэтгэлийн үнэлгээтэй явагдаж байна. | |
| **ХОЁР.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:** | | | | | | | |
| *Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн зорилт, Иргэнд чиглэсэн үйлчилгээ:* | | | | | | | |
| 3 | 2.1.Нийтийн тээврийн шугамын үйлчилгээний цаг, рейсийн алдагдалгүй, смартын ТВОХ-ийн зөрчлийг бууруулж ажиллах. | - | Смартын зөрчлийн цаг | 391 | Смартын зөрчлийн цаг 300 хүртэл бууруулсан байна. | Нийтийн тээврийн шугамын үйлчилгээнд 2022 оны 1 сарын 1-нээс 2022 оны 05 сарын 23 хүртэл хугацаанд нийт 117239:36 цаг 89%-ийн гүйцэтгэлтэй ажилласан. Смартын ТВОХ-ийн зогсоолд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зогсоогүй 105:57 цагийн зөрчил гарсан. | |
| 4 | 2.2.Нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулж, санал гомдлыг бууруулж ажиллах. | - | Санал гомдлын тоо | 16 | Санал гомдлын тоо 15 хүртэл бууруулсан байна. | Нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд жолооч нарт ёс зүй, харилцаа хандлагын талаар сургалт, замын хөдөлгөөний дүрэм, аюулгүй байдлын талаар сургалтыг СХД-н цагдаагийн 2 дугаар хэлтэстэй хамтран явуулсан. Мөн парк шинэчлэлийн хүрээнд 2 давхар цахилгаан автобусыг шугамын үйлчилгээнд явуулж эхэлсэн. Техникийн эвдрэл гэмтэл, жолоочийн зан харилцаатай холбоотой санал гомдол нийт 6 ирсэн. | 100% |
| 5 | 2.3.Тээврийн хэрэгслийн жолоочоос шалтгаалсан ашиглалтын саатал, зам тээврийн осол зөрчлийг бууруулж ажиллах | - | Ашиглалтын саатлын тоо | 1942 | Ашиглалтын саатал 40% хүртэл бууруулсан байна. | Зам тээврийн осол байгууллагын хэмжээнд 47 бүртгэгдсэнээс өөрийн буруутай үйлдэл 27, бусдын буруутай үйлдлээс шалтгаалсан 20 зам тээврийн осол бүртгэгдсэн байна. Өөрийн буруутай 27 зөрчлөөс шалтгаалсан ашиглалтын саатал 91:00 цаг гарсан. | 100% |
| 6 | 2.4.Нийт хөдлөх бүрэлдэхүүнийг техникийн байдалд тогтмол үзлэг хийж, илэрсэн эвдрэл гэмтлүүдийг богино | - | Техникийн бэлэн байдлын коэффициент | 67% | 82,5% | Дансаар 124 тээврийн хэрэгсэлтэй ба техникийн бэлэн байдалд үзлэг шалгалтыг тогтмол хийж, тайлант жилд үзлэгээр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хугацаанд чанартай засварлан техникийн бэлэн байдлын коэффициентыг 82.5 %-иас бууруулахгүй ажиллах | | | | | давхардсан тоогоор бүрэн бус тоормостой 56 автобусыг зогсоож, давхардсан тоогоор 280 автобусны тормос чангалж шугамын үйлчилгээнд ажиллуулсан. Мөн давхардсан тоогоор 185 автобусны гэрэл дохио сольсон, ил харагдах гэмтэлтэй давхардсан тоогоор 74 автобусыг тус тус оношилж, засварлан техникийн бэлэн байдлыг хангаж ажиллав. | |
| 7 | 2.5.Нийт хөдлөх бүрэлдэхүүнийг хавар, намрын техникийн улсын үзлэг оношилгоонд жилд 2 удаа хуваарийн дагуу хамруулах | өөрийн хөрөнгө | Хөдлөх бүрэлдэхүүнийг оношлогоонд хамруулсан хувь | Давхардсан тоогоор 130 | Давхардсан тоогоор 43 | Техникийн хаврын үзлэг оношлогоо 2022.03.15-2022.05.31-ний өдөр явагдаж хамрагдах ёстой тээврийн хэрэгслийн 94,6 % хамрагдаад байна. Оношилгоонд хамрагдаагүй 3 автобус буюу 5,4% нь удаан засвартай, сэлбэгийн олдоц муутай холбоотой зогсож байгаа болно. | 100% |
| 8 | 2.6.Шугамын үйлчилгээний тээврийн хэрэгслийн цэвэрлэгээ, угаалга, ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж хэвших. | өөрийн хөрөнгө | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Шугамын үйлчилгээнд ажиллаж байгаа тээврийн хэрэгслийн цэвэрлэгээ ариутгалыг Тоосгоны үйлдвэрийн эцсийн цэгт, Сэлбэ амралтын буудлын эцсийн цэг, бааз гэсэн гурван цэгт ажиллаж, өдөрт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дунджаар давхардсан тоогоор 82-84 автобусны дотор угаалга, 7-14 автобусны гадна угаалга хийгдэж байна. Сард давхардсан тоогоор дотор угаалга 2604 автобусанд, гадна угаалга 310 автобусанд хийгдсэн. Угаалганы өдөр тутмын мэдээг Viber сүлжээ ашиглан Нийтийн тээврийн цэвэрлэгээ ариутгалын группд мэдээлж байна. | |
| **ГУРАВ.ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ (ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРЭГ)** | | | | | | | |
| *Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилт* | | | | | | | |
| 9 | 3.1.Нийтийн тээврийн үйлчилгээний газартай ажил үйлчилгээний гэрээ, санхүүжилтийн гэрээ байгуулан ажиллах, хэрэгжилтийг хангах | - | Гэрээний биелэлтийн дундаж хувь | 95% | Гэрээний биелэлтийг 95%-иас дээш дүгнүүлсэн байна. | Нийтийн тээврийн газартай гэрээ байгуулан гэрээний дагуу 1 дүгээр сард 91,4%, 2 дугаар сард 92,3%, 3 дугаар сард 91,1%, 4 дүгээр сард 92,9%, 5 дугаар сард 93,4% тус тус дүгнэгдсэн. Дунджаар 92.2% | 92% |
| 10 | 3.2.Батлагдсан цаг графикийн дагуу нийтийн тээврийн шугамын үйлчилгээний өглөөний эх авалт, оройн буултыг бүрэн биелүүлж ажиллах | - | Өглөөний эх авалт, оройн буултын хувь | 94% | Эх авалт, оройн буултыг 95%-иас дээш биелүүлсэн байна. | Нийтийн тээврийн шугамын үйлчилгээнд өглөөний эх авалтыг 94,8%, оройн буултыг 96%-тай биелүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| *Нийтийн тээврийн үйлчилгээний MNS 5012:2011 стандартын шаардлага хангуулах, арга хэмжээг зохион байгуулах хүрээнд:* | | | | | | | |
| 11 | 3.3.Тээврийн хэрэгслийг чиглэлийн хаяг, замнал, гаралтын дугаар, рейс цагийн графикаар бүрэн хангаж, шугамын үйлчилгээнд гаргах. | өөрийн хөрөнгө | Тээврийн хэрэгслийг чиглэлийн хаягаар хангасан хувь | 100% | Бүх тээврийн хэрэгслийг чиглэлийн хаягаар хангасан байна.-100% | Байгууллагын дансны бүртгэлтэй 113 тээврийн хэрэгслээс шугамын үйлчилгээнд ажиллаж байгаа Даевүү-17, Каунти-22, Эко-5 нийт 44 тээврийн хэрэгсэлд 13 чиглэлийн хаягийг хулдаасан болон хөөсөн хаягаар бүрэн хангасан. Цахилгаан 36 автобусны лед хаяг бүрэн ажиллаж байна. | 100% |
| 12 | 3.4.Жолооч нарыг стандарт шаардлагын дагуу ажлын хувцсаар хангаж, шугамын үйлчилгээнд тогтмол өмсүүлж хэвшүүлэх. | өөрийн хөрөнгө | Жолооч нарыг ажлын хувцсаар хангасан хувь | 100% | Автобусны жолооч нарыг стандартын дагуу ажлын хувцсаар хангасан байна.-100% | Нийт жолооч нарыг өвлийн куртикаар бүрэн хангасан. Нийт дансаар 150 жолоочийг өвлийн хувцсаар хангасан. | 100% |
| 13 | 3.5.Шалгагч нарыг хуваарийн дагуу шугамын автобусанд зорчигч нарт зөвлөгөө өгөх, хяналт тавьж ажиллуулах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | 3.5.1.Газрын даргын баталсан 01 дүгээр удирдамжийн дагуу үйлчилж буй 14 чиглэлд орлогын доод хязгаар тогтоох ажлын зураг авалтыг зохион байгуулж ажилласан. Зураг авалтын дүгнэлтээр:<br>1.Шугамын үйлчилгээний 13 чиглэлд ажлын зураг авалтаар шугамын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээнд 77195 зорчигч зорчсоноос картын орлого 41209 төгрөг, хөнгөлөлтэй зорчигчид (ахмад, оюутан, хөнгөлттэй зорчигч, цагдаа, донор, дамжин суу[illegible]т) 35986 буюу 47%-ийг эзэл[illegible] байна.<br>2.Нийтийн тээврийн үйлчилгээний оргил [illegible] ачааллын цагаар шу[illegible]амын орлогын 80 гаруй хув[illegible]ийг олдог гэж тооцоход, ажлын зураг авалт хийсэн ажлын хэсгийн дүгнэлтээр нийтийн тээврийн газраас тогтоож өгсөн орлогын төлөвлөгөөг биелүүлэх боломжгүй гэж үзэж байна.<br>3.ХО:13 "Баруун түрүүн-Таван шар" чиглэлд автобусны карма байхгүй, тэмдэг тэмдэглэгээ байхгүйгээс зам тээврийн осол зөрчил гарах магадлал өндөртэй. Ажлын өдрүүдэд шалгагч нарыг 2 ээлжээр ажиллуулахад 1997 зорчигч зорчсноос 1054 буюу 53% нь хөнгөлөлтэй зорчигч зорчдог.<br>4.Хот орчмын Хо:11 "Хонхор-Офицеруудын ордон", ХО:5 "Налайх-Офицеруудын ордон" чиглэлүүдээс бусад хот орчмын чиглэлийн эцсийн буудлууд дээр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | U-Money карт борлуулах, цэнэглэх цэг байхгүй.<br>5.Бага ангийн сурагчдыг зөөж байгаа эцэг эхчүүд хүүхдийн карт уншуулдаггүй.<br>6.Шалгагчид хуурамч бичиг баримтыг хураах авах, торгох эрх бүхий албан тушаалтан биш учир зөрчилтэй баримт бичигтэй зорчигчдыг автобусаар зорчихыг зогсоох, бичиг баримтыг хураах авах боломжгүй. Зураг авалтаас харахад орлогын доод хязгаар биелүүлэх боломжгүй гэсэн дүгнэлтэд хүрсэн. Дүгнэлтийг газрын даргад танилцуулж, ННТГ-т өдөр бүр орлогын бодит мэдээг хүргүүлж ажилласан.<br>3.5.2.Тайлант хугацаанд давхардсан тоогоор 105 шалгагч хуваарийн дагуу шугамын үйлчилгээнд зорчигчдод зөвлөгөө өгч, хяналт тавьж ажилласан.<br>Давхардсан тоогоор 20 шалгагч пос машинаар карт борлуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Орлогын мэдээ тайлан, посын орлогын талаар Нийтийн тээврийн үйлчилгээний газарт мэдээлж ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3.5.3.2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн парк шинэчлэлтээр орж ирсэн хоёр давхар цахилгаан автобус шугамын үйлчилгээнд ажилласантай холбогдуулан шалгагч нарыг хуваарийн дагуу автобусны хоёр давхарт зөвлөх, аюулгүй ажиллагааг хангаж ажиллуулахаар зааварчилгаа өгч ажиллуулаад байна. | |
| 14 | 3.6.Тээврийн хэрэгслийн ТҮ I,II-ыг батлагдсан хуваарийн дагуу тогтмол хийж, шаардлагатай үед тодотголыг сар бүрийн 20-ны дотор хийж, батлуулах. | өөрийн хөрөнгө | Тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээнд хамрагдсан хувь | 85% | Тээврийн хэрэгслүүдийг 100% техникийн үйлчилгээнд хамруулсан байна. | 2022 оны хагас жилийн байдлаар техникийн үйлчилгээ I болон II-оор үйлчилгээ хийлгэх тээврийн хэрэгслийн хуваарийг батлуулж, мөрдөн ажиллаж байна. 2022 онд нийт дүнгээр 4000-6000 км тутмын техникийн үйлчилгээ I-ээр 39 автобус, 8000-12000 тутмын техникийн үйлчилгээ II-оор давхардсан тоогоор 37 автобус тус тус хамрагдаж, үйлчилгээ хийлгэсэн. | 100% |
| 15 | 3.7.Батлагдсан график төлөвлөгөөний дагуу нийт хөдлөх бүрэлдэхүүний урсгал засварын ажил зохион байгуулах | өөрийн хөрөнгө | Урсгал засварт хамрагдах автобусны тоо | 80 | 120 | 2022 оны эхний хагас жилд урсгал засварыг зохион байгуулах төлөвлөгөөг батлан ажиллуулсан. Төлөвлөгөөний дагуу | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тайлант онд урсгал засвар буюу их засварыг давхардсан тоогоор 2890 автобусанд хийсэн. | |
| 16 | 3.8.Автобусны техникийн саатлыг 2021 оныхоос 50% -иар бууруулах | - | Техникийн саатал цагаар | 10000 | 5000 | Тайлант хугацаанд нийт хөдлөх бүрэлдэхүүн 4731:54 цагийн техникийн саатал гарсан нь хагас жилийн дүнгээр төлөвлөсөн техникийн саатлын 5845 цаг буюу 44,7%-иар тус тус буурсан байна. | 100% |
| 17 | 3.9.Нийт хөдлөх бүрэлдэхүүний гадна өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор кузов засварын ажлыг зохион байгуулах. | өөрийн хөрөнгө | Кузов засварт хамрагдах автобусны тоо | 45 | Нийт тээврийн хэрэгсэл | 2022 оны эхний хагас жилийн кузов засвараар 42 автобус үйлчилгээ хийлгэж, автобусны гаднах өнгө үзэмжийг сайжруулсан. Кузов засвараар үйлчилгээ хийлгэсэн автобусны тоо нэмэгдсэн нь зам тээврийн осол зөрчил, жолооч нарын оролт, гаралт ихэссэнтэй холбоотой юм. | 100% |
| 18 | 3.10.2022-2023 оны Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө гарган батлуулж, хэрэгжүүлж ажиллах | өөрийн хөрөнгө | Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний биелэлтийн хувь | 81% | Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг 85%-с дээш биелүүлэн ажилласан байна. | Байгууллагын 2022-2023 оны Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдөр баталсан ба төлөвлөгөөний биелэлтийг 06 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн тайлагнаж ажиллана. | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ДӨРӨВ.ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ (ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ)** | | | | | | | |
| *Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах* | | | | | | | |
| 19 | 4.1.УИХ-ын болон Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ЗГ-ын тогтоол, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, НЗД-ын зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажиллах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Тайлант хугацаанд МУ-ын Засгийн газрын тогтоол 1, Нийслэлийн Засаг даргын захирамж 3, НЗД-ын хуралдааны тэмдэглэл 1 тус тус ирсний хэрэгжилтийг 100% хангаж ажилласан. Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийг улирал, хагас жилээр НЗДТГ-т тайлагнасан. | 100% |
| 20 | 4.2.Нийслэлийн засаг даргаас тухайн жилд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлж, хэрэгжилтийн мэдээ тайланг хугацаанд нь НЗДТГ-т хүргүүлж ажиллах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | 2022 оныг "Хотын иргэний жил" болгон зарлах тухай захирамжийн хүрээнд тус байгууллагаас хийж хэрэгжүүлэх ажлын саналыг 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01/50 дугаар албан бичиг, хавсралтаар хүргүүлж ажилласан. Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн явагдаж, уг шуурхай дээр НЗД-аас тус | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагад хамааралтай 37 үүрэг даалгавар өгөгдсөн ба 14 хоногийн Пүрэв гаригт биелэлтийг Ulaanbaatar.mn-д хугацаанд нь тайлагнаж байна. | |
| *Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:* | | | | | | | |
| 21 | 4.3.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн захиргааны албан хаагчийн хөрөнгө оруулгын мэдүүлгийг үнэн зөв, хуулийн хугацаанд хүргүүлж ажиллах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Тайлант хугацаанд Газрын дарга, Захиргаа удирдлага, Хүний нөөцийн хэлтсийн дарга, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, Дотоод хяналт, Шалгалтын хэлтсийн дарга, Техник технологийн хэлтсийн дарга, Тээвэрлэлт үйлчилгээний хэлтсийн дарга нар Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хүлээн авч бүртгэн, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэгт заасны дагуу Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн хянуулсан. Мөн холбогдох албан тушаалтнууд ХОМ-ийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| *Гамшгаас хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах хүрээнд:* | | | | | | | |
| 22 | 4.4.Гамшгийн үед байгууллагад авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэн ажиллах. | өөрийн хөрөнгө | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Гамшгийн үед авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байна. | 60% |
| *Шударга байдлыг хангах талаар:* | | | | | | | |
| 23 | 4.5.Байгууллагын "Ажилтнуудын ёс зүйн дүрэм"-ийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны жолооч А нь Засвар үйлчилгээний станцын засварчин ажилтай Б-гийн талаар гомдол мэдүүлж, өргөдөл өгсний дагуу Ёс зүйн хороо 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдөр хуралдаж, асуудлыг тодруулж, цаашид зөв боловсон харьцаж, ёс зүйтэй ажиллах талаар зөвлөсөн. Мөн Ёс зүйн хороо Техник технологийн хэлтсийн даргад тухайн ажилтны 05 дугаар сарын урамшуулалт цалинг хасах санал оруулж асуудлыг шийдвэрлүүлсэн. | 100% |
| *Байгууллагын хөдөлмөр аюулгүй ажиллагааны зохион байгуулалтыг хууль дүрмийн хүрээнд хэрэгжүүлж ажиллах хүрээнд:* | | | | | | | |
| 24 | 4.6.Хөдөлмөрийн аюулгүй байдалд тавих, үзлэг шалгалт хийх, болзошгүй үйлдвэрлэлийн ослоос | өөрийн хөрөнгө-98.5 | Үйлдвэрлэлийн ослын тоо | 0 | 0 | Ажлын байрны урьдчилсан зааварчилгаанд давхардсан тоогоор 89 ажилтан, давтан зааварчилгаанд автобусны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | урьдчилан сэргийлэх, чанаржуулах ажлыг зохион байгуулах. | | | | | жолооч-302, шалгагч-189, техник технологийн хэлтсийн засварчид-96 , шалгах механик-32, сантехникийн засварчид 18, тоног төхөөрөмжийн засварчин-8, гагнуурчин-8, цахилгаанчин-6, мужаан-5, тэрэг тавигч-16, тэрэг угаагч-19, аж ахуйн автомашины жолооч-11, үйлчлэгч-9, конторын албан хаагч болон инженер техникийн ажилчид-85, сэлбэг аж ахуйн нярав-10 давхардсан тоогоор нийт 903 ажилтан хамрагдсан. Тайлант хугацаанд хөдлөх бүрэлдэхүүний техникийн бүрэн бүтэн байдлын үзлэг шалгалтыг 3 удаа, ажлын байрны үзлэг шалгалтыг 8 удаа хийж, илэрсэн зөрчлийн талаар өглөөний шуурхайд мэдээлж биелэлтэд нь хяналт тавьж ажилласан. Үйлдвэрийн осол бүртгэгдээгүй. | |
| 25 | 4.7.Ажилчдыг шаардлагатай нэг бүрийн хөдөлмөр хамгаалллын хувцас, хамгаалах хэрэгслээр хангах. | | Засварчдыг нормын хувцас, хамгаалах хэрэгслээр хангасан хувь | 100% | 100% | Шинээр ажилд орсон буюу ажлын хувцасны эдэлгээний хугацаа дууссан ажилчдад өвлийн куртка 68 ш, зуны хантааз 6 ш, ажлын цамц 11 ш, борооны цув 6 ш, усны гутал 5 ш, ажлын өвлийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гутал 7 ш тус тус хангалт хийж 8,989.471.35 төгрөг зарцуулсан байна. | |
| *Байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын хэрэгжилтийг хангаж, хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгч ажиллах хүрээнд:* | | | | | | | |
| 26 | 4.8.Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээний хэрэгжилтийг дүгнэж ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | 2022 оны эхний хагас жилийн байдлаар байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын биелэлтийг хангаж ажиллаж байна. Тайлант хугацаанд 65 иргэнийг ажлын байраар хангасан. Шинээр ажилд орсон ажилтанд байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, ажлын байрны тодорхойлолтыг танилцуулж, хөдөлмөрийн гэрээ байгуулан, хөдөлмөр хамгааллын зааварчилга өгч ажилласан. | 100% |
| *Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх* | | | | | | | |
| 27 | 4.9."Ажилчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах. | өөрийн хөрөнгө | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Байгууллагын 10 ажилтанг "Гэрлэх ёслолын ордон"-д хуримлуулах ажлыг зохион байгуулж гэрээ байгуулан ажиллаж байна. Одоогийн байдлаар 5 ажилтны ёслолыг үйлдээд байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ажилчдыг дотоод сүлжээнд холбох, мэдээллийн найдвартай аюулгүй байдлыг хангаж ажилласан.<br>Албан хэрэгцээнд зориулсан хуулийн ажилтнуудыг "Төрийн мэдээлэл" сэтгүүлээр хангасан.<br>Албан үүргээ гүйцэтгэж байх үедээ ажилтнуудаас хүчирхийлэл, заналхийлэлд өртөх асуудал гараагүй.<br>Хэлтэс, нэгжийн дарга нар шаардлагатай үед хэсэгчилсэн болон ганцаарчилсан уулзалтыг зохион байгуулж, харилцаа, ажлын байран дах сэтгэл ханамжийн аятай нөхцлийг бүрдүүлсэн.<br>Байгууллагад удаан жил ажилласан 1 ажилтанд 206,381,0 мян.төгрөгийн нэмэгдэл 1 удаа олгосон.<br>Мэргэшсэн инженерийн 2 ажилтанд зэргийн нэмэгдэл олгож байна.<br>Хамтын гэрээний заалт, цалин хөлсний журмын дагуу нийт ажилчдад сар бүр, хоол, унааны хөнгөлөлт олгож байна.<br>Ажилчдын дэлгэрэнгүй судалгаа гаргаж, баяжуулалт хийсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 28 | 4.10.Байгууллагын 2022 оны сургалтын төлөвлөгөөний дагуу ажилчдад зориулсан сургалтыг зохион байгуулах | өөрийн хөрөнгө | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | - Архивын ерөнхий газраас зохион байгуулж буй "Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай" хууль болон түүнийг дагалдан гарсан дүрэм, журмын талаарх албан хаагчдад зориулсан сургалтад 5 хэлстийн дарга, 2 ахлах ажилтан, бусад инженер техникийн 16 ажилтанг тус тус хамруулсан.<br>- Мөн Архивч, хүний нөөц Г.Отгонцэцэг 1 сарын Архив, албан хэрэг хөтлөлтийн анхан шатны сургалтад хамрагдаж мэргэжлийн үнэмлэх авсан.<br>- Шинээр батлагдсан Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаарх сургалтад Хүний нөөцийн ахлах ажилтан, Хуулийн зөвлөх нарыг хамрууллаа.<br>- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи байгууллага дээр зохион байгуулагдсан сургалтад 53 ажилтан тус тус хамрагдсан байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| *Ажилчдын нийгэм халамжийн асуудалд дэмжлэг үзүүлэх чиглэлээр:* | | | | | | | |
| 29 | 4.11.Орон гэргүй, түрээсийн орон сууцад амьдарч байгаа ажилтнуудын асуудлыг шийдвэрлэх зорилгоор холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | Түрээсийн орон сууц хөтөлбөрт 3 ажилтан, гэр олгох 3 өрхийг дэмжинэ. | 2022 оны 2 дугаар сараас эхлэн 2 удаагийн ажилчдын ар гэр, амьжиргааны талаархи судалгааг авсан. Үүнд 110-150 ажилтан хамрагдсан. Үүнтэй уялдуулан 3 дугаар улиралд багтаан 5 ажилтны нэрийг уламжлахаар төлөвлөж байна. Бүрдүүлэх бичиг баримтын төслийг холбогдох байгууллагаас авсан. Квот авахаар албан бичгийг холбогдох газарт хүргүүлээдбайна. | 30% |
| 30 | 4.12.Байгууллагын ажилчдын цэцэрлэгийн насны хүүхдүүдийг 24 цагийн үйл ажиллагаатай цэцэрлэгт хамруулж, урлаг спортын авьяастай хүүхдүүдэд урамшуулал олгох ажлыг зохион байгуулах. | - | Ажилчдын хүүхдүүдийг цэцэрлэгт хамруулсан тоо | 14 | 15 | Байгууллагын ажилтнуудын хүүхдийг цэцэрлэгт хамруулах зорилгоор байгууллагын ойр 24 цагийн үйлчилгээтэй СБД-ийн 54 дүгээр цэцэрлэгтэй байгуулсан гэрээний дагуу 14 хүүхдийг хамруулсан. | |
| 31 | 4.13.Байгууллагын захиргаа болон ҮЭ-ийн хороо хоорондын "Хамтын гэрээ"-ний дагуу ажилчдын нийгмийн асуудлыг шийдэж ажиллах. | өөрийн хөрөнгө | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Байгууллагын захиргаа болон ҮЭ-ийн хороо хоорондын "Хамтын гэрээ"-ний дагуу 2022 оны эхний хагас жилд тус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаад өндөр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | насны тэтгэвэрт гарсан 3 ажилтанд нийт 38,403,0 мян.төгрөгийн тэтгэмж олгосон. Мөн төрсөн эцэг, эх нь нас барсан 19 ажилтанд нийт 7,100,0 мян.төгрөгийн, 8 ажилтанд 5-10 хоногийн цалинтай чөлөөг тус тус байгууллагын даргын тушаалаар олгосон. | |
| 32 | 4.14.Ажилчдаас сэтгэл ханамжийн болон ажлын орчин нөхцөлийн судалгааг авч нэгтгэж, удирдлагад тайлагнах | - | Судалгаанд оролцсон ажилтнуудын тоо | 117 | Түүврийн аргаар 1 удаад 150-200 ажилтнаас авах | Ажилчдаас сэтгэл ханамжийн болон ажлын орчин нөхцөлийн судалгааг авч удирдлагад танилцуулж ажилласан. | 100% |
| *Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн хүрээнд:* | | | | | | | |
| 33 | 4.15.Нээлттэй ажлын байрны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, вэб сайтад зарлаж, сонгон шалгаруулалтыг хийж, байгууллагын хүний нөөцийг бүрдүүлж ажиллах. | - | Нээлттэй ажлын байрны зарыг мэдээллийн хэрэгслээр зарлах тоо | 6 | 8 | Тайлант хугацаанд нээлттэй ажлын байрны зарыг шуурхай зар сонин, FM 88,3 радио, СХД-ийн хороодын ойролцоо цаасаар нааж, байгууллагын албан ёсны пейж хуудсаар дамжуулан тасралтгүй share хийн явуулж, нийт 65 иргэнийг сонгон шалгаруулж ажилд авсан. СХД-ийн Хөдөлмөр, халамжийн газартай хамтран ажиллаж, ажлын байрны нээлттэй өдөрлөгт 1 удаа, ШУТИС-ийн Механик инженерийн сургуулиас | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зохион байгуулсан нээлттэй өдөрлөгт 1 удаа тус тус оролцож сул ажлын байрны талаархи мэдээ, мэдээллийг хүргэж ажилласан. | |
| 34 | 4.16.Байгууллагын хэлтэс, нэгжийн төлөвлөгөө, тайлангийн биелэлт, сарын ажлын гүйцэтгэл, үр дүнг дүгнэж ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | -Дотоод хяналт, шалгалтын хэлтсийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөг газрын даргаар батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна. -Хэлтсийн ажилчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг ажилтан тус бүр хэлтсийн даргаар батлуулан мөрдөж ажиллана. Сар бүр ажилчдын ажлын гүйцэтгэлийг хэлэлцэн, урамшуулалт цалинтай уялдуулан ажилласан. Тайлант хугацаанд 3 ажилтны урамшуулалт цалинг 2-5%-иар хасч тооцсон. | 100% |
| 35 | 4.17.Улсад болон салбар, тус байгууллагад олон жил тогтвор суурьшилтай, ажлын үр бүтээлтэй, амжилттай ажиллаж байгаа ажилчдыг төрийн дээд одон медаль, салбар, нийслэлийн шагналаар шагнуулахаар тодорхойлох, шийдвэрлэх | өөрийн хөрөнгө | Шагнуулах ажилчдын тоо | 45 | 45 | 2022 он эхний хагас жилд манай байгууллагаас Төрийн дээд одон-5, салбарын тэргүүн-6, тээврийн салбарын шагнал-8, байгууллагын шагналаар 12 ажилтан шагнуулсан байна. Мөн 2 дугаар улиралдаа багтааж төрийн дээд одонгоор 23 ажилтанг уламжлахаар бэлтгэл ажлыг хангасан байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 36 | 4.18.Ажилчдыг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулах, хяналтад авах, ажилчдад эмчилгээ хийх, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулан ажиллах | Өөрийн хөрөнгө-60,0 | Эмнэлгийн үзлэгт хамрагдах ажилчдын тоо | - | Ажилтнуудын 85,0-иас дээш хувь хамрагдана | Эрүүл мэндийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг (нүд, чих-хамар хоолой, мэдрэл, дотор, мэс засал, арьс харшил) шинжилгээнд 315 ажилтан хамрагдахаас 220 ажилтан хамрагдсан ба 95 ажилтан (ээлжийн амралттай, өвчтэй буюу эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн, чөлөөтэй, асуудал шийдэгдэх ажилтан тус тус багтаж байгаа болно). Амбулаториор давтан үзлэг шинжилгээ хийлгэж онош тодруулан эмчлүүлэх шаарлагатай-6 ажилтан байлаа.<br>2022 оны эхний хагас жилийн байдлаар байгууллагын эмч 766 ажилтанг оношилж, эмчлэн, зөвлөгөө өгсөн ба үүнээс эмийн эмчилгээ–415 ажилтанд, эмийн бус эмчилгээ–226 (боолт хийх, анхан шатны тусламж, бумба, бариа гэх мэт), тариа (дусал, судас, булчин)-125 хүнд хийж тус тус үйлчилгээ үзүүлсэн байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| *Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хүрээнд:* | | | | | | | |
| 3 | 4.19.Төрийн албан хэрэг хөтлөлт, архивын ажлыг стандартын дагуу явуулж, тайлан гаргаж ажиллах. | - | Тайланг журмын дагуу гаргана. | 100% | Тайланг хугацаанд нь хүргүүлсэн байна. | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын дагуу байгууллагын албан хэрэг хөтлөлт, архивын ажлыг хийж гүйцэтгэж байна. | 100% |
| 36 | 4.20.Байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлтийг хийж ажиллах. | - | 2020 оны нөхөн бүрдүүлэлтийг бүрэн хийсэн байна. | 100% | 100% | 2022 оны батлагдсан хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлт хийсэн. | 100% |
| 37 | 4.21.Хариутай албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажиллаж, тайланг гаргах. | - | Албан бичиг шийдвэрлэлтийн хувь | 100% | 100% | 2022 оны 01 сарын 01-нээс 2022 оны 06 сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд тус байгууллагад байгууллагаар бүртгэгдсэн 164, системээр бүртгэгдсэн 162, нийт 164 албан бичиг ирснээс, хариутай албан бичиг 51, хариугүй албан бичиг 113 байсан. Хариутай албан бичгийн хугацаандаа шийдвэрлэсэн 49 буюу 96%, судалж байгаа 2 албан бичиг буюу 4%-ийг тус тус ээлж байна. Нийт ирсэн албан бичгийн шийдвэрлэлтийн хувь 98,98, шийдвэрлэлтийн дундаж 5,68 байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 38 | 4.22.Байгууллагын ажилчид болон гадны байгууллага, иргэдээс өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, тайлан мэдээг НЗДТГ-т хугацаанд нь хүргүүлж ажиллах | - | Ирсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэлтийн хувь | 100% | 100% | 2022 оны 01 сарын 01-нээс 2022 оны 06 сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд тус байгууллагад ННЗБ бүртгэсэн нийт 203 хүсэлт, өргөдөл гомдол ирсэн байна. Хугацаандаа шийдвэрлэсэн 203 хүсэлт буюу 94,42%, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн хүсэлт байхгүй, хугацаандаа байгаа 12 хүсэлт буюу 5,58% тус тус эзэлж байна.<br>Өдөрт нь багтаан шилжүүлээгүй болон өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил байхгүй байна. Өргөдөл гомдлыг 5 хоногт шийдвэрлэсэн 98 буюу 48,28%, 10 хоногт шийдвэрлэсэн 78 буюу 38,42%, 15 хоногт шийдвэрлэсэн 25 буюу 12,32%, 30 хоногт шийдвэрлэсэн 2 буюу 0,99%, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн хүсэлт байхгүй байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 5 хоног, 9 цаг, 21 минут байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| *Биеийн тамирын тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд* | | | | | | | |
| 39 | 4.23.Нийт ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх зорилгоор хөгжөөнт болон спортын тэмцээн, уралдаан, наадам, явган аялал, цасны баяр зохион байгуулах | өөрийн хөрөнгө | Зохион байгуулах арга хэмжээ, тоо | 2 | 3 | Нийслэлийн Засаг даргын санаачлагаар Марафон-2022 уралдааны хүрээнд байгууллагын 23 ажилтанг хамруулсан. Мөн "Идэвхтэй хөдөлгөөн-эрүүл мэнд" аяны хүрээнд долоо хоног бүрийн 4 дэх өдрийн 15 цагаас 17 цагийн хооронд спорт зааланд гар бөмбөг болон сагсан бөмбөгөөр хичээллүүлж байна. | 100% |
| *Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах* | | | | | | | |
| 40 | 4.24.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дундын мэдээллийн сан <u>www.erp.ulaanbaatar.mn</u>, цахим хуудсыг байгууллагын үйл ажиллагаанд ашиглах | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дундын мэдээллийн сан www.erp.ulaanbaatar.mn, цахим хуудсыг нийт Захиргаа, инженер техникийн ажилтнууд ашиглаж хэвшсэн ба удирдах дээд газар болон байгууллага хооронд мэдээлэл солилцож, өгч буй цаг үеийн мэдээллийг цаг алдалгүй авч ажил үүрэгтээ хэрэгжүүлэн ажиллаж байна. Удирдах болон бусад ажилтан, албан хаагчид, инженер техникийн ажилтнуудын цагийн бүртгэлд өдөр тутам ERP системээр хяналт тавьсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 41 | Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд Тоон гарын үсэг хэрэглэж хэвших | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | МУ-ын Засгийн газрын 2016-2020 оны "Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн IV шат, Цахим гарын үсгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дах хэсэг, НЗД-ын 2020 оны А/453 дугаар захирамжаар батлагдсан "Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх талаар хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" зэрэг эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангах хүрээнд тус байгууллага нь 2021 оны 04 сарын 27-ны өдрөөс эхлэн цахим албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд тоон гарын үсэг хэрэглэн ажиллаж байна. | 100% |
| *Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах* | | | | | | | |
| 42 | 4.25.Байгууллагын үйл ажиллагааг сонин хэвлэл, телевиз, вэб хуудас, мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулах | өөрийн хөрөнгө | Сурталчилгаа явуулсан тоо | 2 | 3 | Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэл болон нийтийн тээврийн парк шинэчлэлтэй холбоотой мэдээллийг өөрийн пэйж хуудас болон сайт, гэрээт байгууллагуудаар мэдээллэхээс гадна байгууллагын үйл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагааг цаг тухай бүрт нь мэдээ мэдээллийг иргэдэд мэдээллэж ажилласан. Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлж буй ажил болон өдөр тутмын мэдээллийг 25, нийтийн тээврийн газар болон цагдаагийн ерөнхий газрын мэдээллийг 8, байгууллагын үйл ажиллагаа болон зар мэдээ 39 гэх мэт мэдээллүүдийг өөрийн пэйж хуудас болон СХД-ийн 43 хороодын нэгтсэн хуудсуудад мэдээллэж ил тод байдлыг хангаж ажиллалаа. Мөн онцлох мэдээ мэдээллийг Манд.мн, 1-р суваг.мн гэх мэт цахим телевизээр мэдээллэсэн байна. Мөн тараах материал болон хэвлэлийг гэрээт 2 байгууллагаар 12 нэр төрлийн эхийг бэлтгэж өгч хэвлүүлж үйл ажиллагаандаа ашигласан байна. Нийслэлийн нийгэм, эдийн засгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, НЗД-ын 2021-2025 оны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд тус байгууллага 2022 оны 05 сард байгаль орчинд ээлтэй Цахилгаан хөдөлгүүртэй 2 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | давхар 10 ш эко автобусаар парк шинэчлэлт хийсэн ба дээрх ажлын талаар телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр тус тус мэдээлж сурталчилсан. | |
| 43 | 4.26.Нийтийн тээврийн үйлчилгээний талаарх эерэг мэдээллийг олон нийтэд түгээх зорилгоор мэргэжлийн PR-ийн байгууллагатай хамтран ажиллах | өөрийн хөрөнгө | Эерэг мэдээллийг олон нийтэд түгээсэн тоо | 2 | 2 | Телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр 3 шторк, 4 мэдээг бэлтгэн нийтлүүлсэн байна. | 100% |
| 44 | 4.27.Холбогдох чиг үүргийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагуудтай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | 4.27.1 Нийслэлийн нийтийн тээврийн газрын тээврийн хяналтын хэлтэстэй шалгагч нарын хийж гүйцэтгэсэн ажлын тайлан болон бусад холбогдох асуудлын хүрээнд хамтарч ажилласан. Тайлант хугацаанд өдөр бүр орлогын мэдээ, зорчигч урсгалын тайлан хүргүүлсэн. 4.27.2."Улаанбаатар смарт карт" ХХК-тай хамтран онлайн камерын үйл ажиллагааг хангах чиглэлийн хүрээнд 8 удаагийн засвар үйлчилгээний ажлыг зохион байгуулсан. Шинээр ирсэн 10 ширхэг 2 давхар автобус дээр смартын тоног | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төхөөрөмжийг суурилуулж шугамын үйлчилгээнд ажиллахад бэлэн болгосон. | |
| *Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх* | | | | | | | |
| 45 | 4.28.Гадаадын улс орнуудын нийтийн тээврийн байгууллагуудаас туршлага судлан, тэргүүний техник, технологи нэвтрүүлэх | өөрийн хөрөнгө | Туршлага судалсан тоо | - | 1 | Тус байгууллага гадаадын орнуудын нийтийн тээврийн автобусны судалгаа хийсний үндсэн дээр парк шинэчлэлтийн хүрээнд орчин үеийн, шинэ техник технологийн байгаль орчинд ээлтэй их багтаамжийн дан болон 2 давхар цахилгаан автобусыг 2022 онд Монгол Улсад анх удаа нийтийн тээвэрт нэвтрүүлсэн ба улмаар 2022 оны 05 дугаар сард 10 ш хоёр давхар автобусыг нийлүүлж шугамын үйлчилгээнд ажиллуулж байна. | 100% |
| *Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хууль эрх зүйн болон арга зүйн зөвлөгөө үзүүлэх* | | | | | | | |
| 46 | 4.29.Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг тухай бүр шинэчлэх | - | Дүрэм, журам, заавар шинэчилсэн тоо | 3 | 5 дүрэм, журам заавар шинэчлэнэ. | 2022 оны эхний хагас жилд дараах, журам, гэрээг шинэчлэн боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан. Үүнд: | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - "Хөдөлмөрийн дотоод журам" 2022 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/08 тоот тушаалаар<br>- "Ажлын байрны тодорхойлолт"-ыг 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/09 тоот тушаалаар<br>- "Цалин хөлсний журам"-ыг 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/29 тоот тушаалаар<br>-"Хөдөлмөрийн гэрээ" болон бусад дагалдах гэрээг шинэчлэн боловсруулж бүх ажилчидтай байгуулан ажиллаж байна. | |
| 47 | 4.30.Байгууллагын хууль эрх зүйн орчинг бүрдүүлж, аливаа эрсдэлээс сэргийлэх, сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах, ажилчдад хууль эрх зүйн зөвлөгөө өгөх | - | Сургалт, хууль эрх зүйн зөвлөгөө өгсөн тоо | 3 | 3 | Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдал, өндөржүүлсэн бэлэн байдалтай тус тус холбогдуулан нийт ажилчдыг хамарсан сургалтыг 3 дугаар улиралд зохион байгуулахаар холбогдох газарт уламжилсан.<br>Зам тээврийн осол зөрчил 47 бүртгэгдсэнээс манай жолоочийн өөрийн буруутай 27 жолоочид ганцаарчилсан давтан зааварчилгаа болон хууль эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 48 | 4.31.Эрхлэх асуудлын хүрээнд үүссэн шүүхийн маргааны шийдвэрлэлт, явц, үр дүнгийн талаар дээд шатны байгууллагад тогтоосон хугацаанд тайлагнаж мэдээлэх | - | Шүүхийн маргааны шийдвэрлэлтийн хувь | 100% | 100% | Хуулийн зөвлөх иргэний нэхэмжлэгчээр-2, хариуцагчаар-5, нэхэмжлэгчээр-3 тус тус татагдсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн этгээдийг төлөөлөн ажилласан.<br>Мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дагуу 9 шүүх хуралд оролцсон байна. | 100% |
| *Төсөв, санхүү, эдийн засаг, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах* | | | | | | | |
| 49 | 4.33.Байгууллагын 2022 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтыг бодит тоо баримт, мэдээлэлд үндэслэн тооцоолох. | Орлого-25,865,0<br>Зардал-32,774,0 | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна.<br>-Байгууллагын өдөр тутмын НББүртгэлийг хөтлөн явуулж, холбогдох журнал ордерт эхний 5 сарын бичилтүүд хийгдсэн.<br>Харилцах данс мөнгөн хөрөнгийн төлбөр тооцоог хүлээн авсан нэхэмжлэхийн дагуу 5 сарын байдлаар орлогын 17,750,521,589.00 төгрөгийн, зарлагын 18,275,584,857.91 төгрөгийн нийт 688 ажил гүйлгээ, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | кассын орлогын 58,072,732.00 төгрөгийн, зарлагын 57,629,124.72 төгрөгийн нийт 292 гүйлгээг тус тус хийж НББ-ийн холбогдох журналд тусгасан. | |
| | | | | | | Эхний 5 сарын байдлаар сар бүрийн 13-ны өдөр ажиллагсадын цалингийн урьдчилгаанд 456,672,200.0 төгрөгийг, 28,29-ны өдрүүдэд сарын эцсийн цалинд 998,400,292.43 төгрөгийг давхардсан тоогоор 393 ажилтанд тус тус тавьж олгосон. Сар бүр НД-ын тайланг гарган СБД-ийн НД-ын газартай тооцооны үлдэгдлийг актаар баталгаажуулан ажиллаж байна. | |
| | | | | | | Сэлбэг материал,хангамж аж ахуйн нярав нь сар бүр агуулахын бүртгэлийн дэвтэр хөтлөн сарын эцэст хариуцсан нягтлан бодогчоор гарын үсэг зуруулан баталгаажилт хийлгэн ажиллаж хэвшсэн. Сард дунджаар тус байгууллагад ажиллаж байгаа 348 ажилтны цалинг холбогдох хууль тогтоомжийн дагуу бодож, цалингаас хувь хүний | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | орлогын албан татвар, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл, шүүхийн шийдвэр, байгууллагад учруулсан хохирлын актын төлбөр зэрэг суутгалуудыг хуульд заасан журмын дагуу ажилтаны цалингийн 50 хувиас хэтрүүлэхгүй суутган олгож байна. | |
| | | | | | | Эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийн хөдөлгөөнийг хөдөлгөөн гарсан тухай бүрт нь шинэчлэн ажилтнуудын хугацаа дууссан болон шинээр авсан хөдөлмөр хамгааллын хувцасны картыг шинэчлэн хөтөлж үргэлжлүүлэн бүртгэлжүүлж хэвшсэнээр бүртгэлээр тавих хяналт сайжирсан. | |
| | | | | | | Байгууллагын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд "Бэст Фортуна аудит" ХХК хяналт шалгалт хийж "Зөрчилгүй" санал дүгнэлт өгөв. | |
| | | | | | | Сар бүрийн 22, 31–ний өдрүүдэд тээврийн хэрэгслийн банкан дах түлшний хэмжилтийн хуваарьт захиргааны бүх ажиллагсдыг хамруулан оруулж хэрэгжилтийг хангуулан ажиллаж хэвшсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 50 | 4.35.Байгууллагын он дамжсан өр авлагыг үе шаттайгаар бууруулж ажиллах. | 1,926.6 | Өр авлагыг бууруулсан хувь | 30% | 40% | Халагдсан авлага-26,4%, сэлбэг-51,8%, шатахуун-60%,ХХОАТ-ын дундын суутгал-71%, НДШ-0,6%, байгууллагад төлөх өглөгийг-68%-р тус тус бууруулан ажилласан. | 50% |
| 51 | 4.36.Тогтоосон хууль тогтоомжийн дагуу байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хугацаанд нь хийж, ашиглалтын хугацаа дууссан, үлдэгдэл өртөггүй, шаардлага хангахгүй болсон тавилга эд хогшлыг актлуулах, саналыг НӨАУГ-т хүргүүлэх. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | Тооллого явуулсан байна. | МУ-ын Засгийн газрын 2020 оны 09 дүгээр тогтоолын дагуу газрын даргын 2022.05.05-ны өдрийн А/35 тоот тушаал гарч тооллогын салбар комисс үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 8 дансдын 34,702,530,460.91 төгрөгийн 47,563 ширхэг үндсэн хөрөнгүүдийг 2021 оны жилийн эцсийн байдлаар хугацаанд нь тоолж дуусгасан.<br>2022 оны 02 дугаар сард НӨХГын даргын А/22 тоот тушаалаар 28,644,833.20 төгрөгийн дансны үнэтэй кузов цехийн барилга 1ш, НӨХГ-ын даргын А/41 тоот тушаалаар 5 ш буюу нийт 644,499,900 төгрөгийн үнэтэй экобус автобусыг тус тус данс бүртгэлээс хассан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 52 | 4.37.Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөгөөний дагуу явуулах | өөрийн хөрөнгө | Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 03 тоот тогтоолоор 2022-2023 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах 7,632,498,490 төгрөгийн 29 ажил /үүнээс НТШ-11 ажил, ТШОЖ-13 ажил, Зөвлөх үйлчилгээ-1 ажил, Зөвлөхөөс бусад үйлчилгээ-2 ажил, Шууд худалдан авалт-2 ажил/ батлагдсанаас 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар Гэрээ хийгдсэн-6 ажил, Үнэлгээ хийгдэж байгаа-4 ажил, Зарлаад хүчингүй болсон-1 ажил, Зарлагдаагүй-16 ажил, Шууд худалдан авалт хийгдээгүй байгаа-2 ажил байна.<br>Гэрээ хийгдсэн ажлууд:<br>1.Аккумлятор,<br>2.Давхар автобусны хамгаалалтын хуулга,<br>3.Түлш хэмжигч,<br>4.Дизель түлшний октан дээшлүүлэгч,<br>5.Харуул хамгаалтын үйлчилгээ,<br>6.Даатгалын үйлчилгээ | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 53 | 4.38.Тендерийн хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд: Худалдан авах ажиллагааг 100% цахим хэлбэрээр явуулж, иргэд, олон нийтийн оролцоо, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналтыг сайжруулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Худалдан авах ажиллагааг тендерийн хуулийн дагуу 100% цахим хэлбэрээр явуулж, иргэдэд ил тод, нээлттэй явуулсан. | 100% |
| *Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах* | | | | | | | |
| 54 | 4.39.Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах | - | Хяналт шинжилгээ, үнэлгээний хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Тайлант хугацаанд Засгийн газрын 5 тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж 10, Нийслэлийн засаг даргын хуралдааны тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгавар 2 нийт 17 хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо хэрэгжилтийг 100% хангаж ажилласан. | 100% |
| 55 | 4.40.Байгууллагын эхний хагас жилийн тайланд явцын үнэлгээ, жилийн эцсийн тайланд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгч, зөвлөмж хүргүүлэх | - | Хяналт шинжилгээ, үнэлгээний хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Байгууллагын эхний хагас жилийн тайлан 2022 оны 07 дугаар сарын 05-ны дотор гарахаар явцын үнэлгээ хийж зөвлөмж хүргүүлэн ажиллана. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 56 | 4.41.Байгууллагын харьяа нэгжүүдийн үндсэн үйл ажиллагаанд төлөвлөгөөний дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ажиллах | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100% | 100% | -Газрын даргын баталсан 02 дугаар удирдамжийн дагуу Санхүү, бүртгэлийн хэлтсийн 2021 оны үйл ажиллагаанд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Газрын даргын баталсан 2022 оны 02 дугаар удирдамжийн 2022 оны 03 сарын 01-ний өдрөөс эхлэн 04 сарын 22–ны өдрийн хооронд Санхүү, бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж ажилласан. Шалгалтаар 23 зөрчил илэрсэн. Хийсэн ажлын тайланг газрын даргад танилцуулж, СБХ-т зөвлөмж, зөрчлийн хуудасны хамт хүргүүлсэн. СБХ-ээс зөвлөмжийн дагуу хийсэн ажлын тайлан ирүүлсэн.<br>-Техникийн бүрэн бүтэн байдал:<br>1.Түлшний банкны таг, бариул, багана, шал, тааз,толь, шил (салхины, хажуу, хойд), хагас голын боолт, шифилька, дохио, гэрэл<br>(хол, ойр, ухрах, заалны гэрэл) нийт арван зургаан үзүүлэлтээр шалгахад 40 автобус буюу | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 72,7% нь зөрчилтэй, техникийн бүрэн бүтэн байдал хангалтгүй байсан. Дүгнэлтийг зөрчлийн хуудсаар Техник, технологийн хэлтсийн даргад танилцуулж зөрчлийг арилгах арга хэмжээ зохион байгуулж, 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор хариу ирүүлэх мэдэгдэл өгсөн.<br>-Нийслэлийн нийтийн тээвэртэй байгуулсан гэрээний үүргийн биелэлтэд хяналт -шинжилгээ, үнэлгээний ажлыг зохион байгуулсан. 2022 оны 1 дүгээр улиралд 78204:52:00 даалгаварт цаг гүйцэтгэхээс 68663:20:30 цаг гүйцэтгэж, нийт 9541:32:30 цагийг алдагдалтай үүнээс ашиглалт, техникийн саатлтай цаг, жолоочоос хасах цаг нийт 5657:48:30 цаг, смартаас авах 2394:21:30 цагийг аваагүй тухай бүрт алдагдсан цагийг авсан талаар ээлжийн инженерүүдтэй тулгалт хийж тооцдоггүйгээс даалгаварт цагийн гүйцэтгэлийн хувь 90%-д хүрээгүй. Өмнөх оны мөн 1 дүгээр улиралтай | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | харьцуулахад ашиглалтын саатал 1007:20:30 цагаар өссөн, жолоочоос хасах цаг 51:27:30 цагаар өссөн, смартаас авах зөрүү цаг 2414:33:00 цагаар өссөн.Цагийн гүйцэтгэлийн хувь 2021 оны 1 дүгээр улиралд 97,4 % байсан бол 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 87,7% гүйцэтгэж 9,7%-иар буурсан. Зөрчлийг газрын даргад болон ТҮХ-ийн дарга М.Сонинбаатар нарт танилцуулж, илэрсэн зөрчлүүдийг арилгах, цаашид ажлаа сайжруулах талаар ажлын төлөвлөгөө гарган холбогдох материалын хамт Дотоод хяналт, шалгалтын хэлтэст 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлэх талаар зөвлөмж хүргүүлсэн.<br>-Зам тээврийн осол, зөрчил гаргасан ТҮХ-ийн автобусны жолооч нарын зөрчлийн мэдээг гаргаж хэлтсийн дарга М.Сонинбаатарт танилцуулан, зөрчил гаргасан жолооч нарт сургалт зохион байгуулж, аюулгүй ажиллагааны давтан зааварчилгаа өгөх талаар зөвлөмж хүргүүлж, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хяналтын шалгалтыг хийхэд 6 жолоочид аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөөгүй байсныг нөхөж өгүүлсэн.<br>-Газрын даргын үйл ажиллагааны чиглэлээр гаргасан А тушаалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг зохион байгуулж холбогдох хэлтсүүдэд тушаалын хэрэгжилтийн тайлан ирүүлэх мэдэгдэл өгсөн. Санхүү, бүртгэлийн хэлтэс, Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтэс, Техник, технологийн хэлтсээс хэрэгжилтийн тайлан ирүүлсэн. ЗУХНХ, ХАБЭААХА- нар хэрэгжилтийн тайлан ирүүлээгүй.<br>-Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж буй автобусны жолооч нар 5 төрлийн 334 зөрчил гаргасан. Зөрчил дутагдлыг арилгуулах талаар Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтэст 3 удаагийн зөвлөмж хүргүүлсэн хоёр зөвлөмжийн хариуг ирүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 57 | 4.42.Тээврийн хэрэгслийн GPS-ийн хяналтын системийг хэрэгжүүлэх, тээврийн хэрэгслийн смартын тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангуулах. | - | Тээврийн хэрэгслийн смартын төхөөрөмжийн бэлэн байдлыг хангасан хувь | 100% | 100% | -Тайлант хугацаанд 11 удаа давхардсан тоогоор 71 автобусанд засвар үйлчилгээний ажлыг "Улаанбаатар смарт карт" ХХК-ны засварын инженерүүдтэй хамтран хийж, хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан.<br>-Парк шинэчлэлтийн хүрээнд орж ирсэн 11 автобуснаас 11 автобусанд смарт тоног төхөөрөмжийг суурилуулах ажлыг хийж шугамын үйлчилгээнд гаргасан. | 100% |

*Төлөвлөгөөг хянасан:* ***Төсвийн Ерөнхийлөн захирагч***

........................ ........................ /................................/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*(огноо)*

*Тэмдэг* ..............................

*Төлөвлөгөө тайлагнасан:* ***Төсвийн Шууд захирагч***

Захиргаа удирдлага, Хүний нөөцийн хэлтсийн дарга /П.Алтантөгс/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*(огноо)*

*Тэмдэг* ..............................

___oOo___